



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/39

Номгон

Цэвэрлэх үйл ажиллагаанд шаардлагатай
10 тонн давс авахад хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Баянхонгор-Тохижилт” үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар албан хүсэлтийн дагуу цас цэвэрлэх үйл ажиллагаанд шаардагдах 10 тонн давс худалдан авах зардлыг шийдвэрлэсүгэй.

2. Дээрх давсны зардал болох 6,500,000 (Зургаан сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

